

**ОУСК-иас Монгол улсын санхүүгийн салбарт
Тогтвортой/ногоон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх,
Уур амьсгалын эрсдэлийг үнэлэхтэй холбоотой
хэрэгжүүлж/хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл
ажиллагааны танилцуулга**

2021 оны 9 сарын 6



Creating Markets, Creating Opportunities

**Б.Батмөнх
ОУСК**

АГУУЛГА

- Тогтвортой санхүүгийн тогтолцоог хөгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа
- ОУСК-ийн Ногоон санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх төсөл
- Уур амьсгалын эрсдэлийг үнэлэх, зохицуулагч байгууллагын зүгээс авах арга хэмжээ
- Дэлхийн банкны бүлэг/ОУСК-иас Уур амьсгалын эрсдэлийг үнэлэхтэй холбоотой үзүүлэх дэмжлэг, хамтын ажиллагаа
- Ногоон бонд

ТОГТВОРТОЙ САНХҮҮГИЙН ТОГТОЛЦОО ГЭЖ ЮУ ВЭ?

1. Ямар нэг төсөл, бизнесийн үйл ажиллагаанд зээл, санхүүжилт олгохоос өмнө тухайн төсөл, бизнес нь байгаль орчин, нийгэмд ямар нэг сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл байгаа эсэхийг шалгах, тухайн эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах, эсвэл санхүүжүүлэхээс татгалзах – **Байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийн удирдлага**
2. Байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хийг бууруулахад чиглэсэн төсөл хөтөлбөр буюу ногоон төслийг санхүүжүүлэх үйл ажиллагаа - **Ногоон санхүүжилт**

ТОГТВОРТОЙ САНХҮҮГИЙН ТОГТОЛЦООГ ЯАГААД ХӨГЖҮҮЛЭХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

- Санхүүгийн салбарын эрсдэл даах чадвар, эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулахаас гадна ногоон төслийг санхүүжүүлэх сонирхолтой хөрөнгө оруулагчдыг татах, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх боломжтой.



МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ САНХҮҮГИЙН ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ



Сургалт, мэдээлэл, уулзалт

- Монгол банк
- Санхүүгийн зохицуулах хороо
- Байгаль орчин аялал жуулчлалын яам
- Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо (ToC Холбоо)
- Монголын Банкны Холбоо
- ББСБ-уудын Холбоо
- Арилжааны банкууд
- ББСБ-ууд
- Олон улсын байгууллагууд

МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ САНХҮҮГИЙН ЗАРЧИМУУД

1. Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын систем (БОНУС)

₮50 саяас дээш, 12 сараас урт хугацаатай хөрөнгө оруулалт

- Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн түвшинг үнэлэх
- Байгаль орчин, нийгмийн шаардлага тавих
- Байгаль орчин, нийгмийн шаардлагын биелэлтийг хянах






Хуулийн дагуу эсэх

2. Ногоон санхүүжилт


Хөнгөлөлттэй эх үүсвэр, “Ногоон таксономи”-д тодорхойлсон бүтээгдэхүүнүүд

- Бохирдол бага үүсгэдэг
- Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулдаг

+Байгаль орчинд ээлтэй эсэх



МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ САНХҮҮГИЙН ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ



Тогтвортой санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийн тайлан – 2018 он

- Argentina, Jordan, Ecuador
- Cambodia, Lao PDR
- Chile, Nepal, Pakistan
- Dominican Republic, Panama
- Egypt, Paraguay
- Fiji, Philippines
- Georgia, Sri Lanka
- Ghana, Thailand
- Honduras
- India
- Kyrgyzstan (new)
- Kenya, Mexico, Morocco, Peru, South Africa, Turkey
- Bangladesh, Brazil, China, Colombia, Indonesia, Mongolia, Nigeria, Vietnam



Тогтвортой санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийн тайлан – 2019 он

ОУСК НОГООН САНХҮҮЖИЛТИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

Монгол Улсад байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хийг бууруулахад чиглэсэн ногоон санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх мөн санхүүгийн салбарт тогтвортой санхүүгийн тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжилтийн үйл ажиллагааг сайжируулах

Төсөл нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдийн хүрээнд хэрэгжинэ. Үүнд:

- **Ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүнийг (ногоон бонд) зах зээл дээр гаргахад чиглэсэн холбогдох заавар журмыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах. Мөн үүнтэй холбоотойгоор зохицуулагч байгууллагын чадавхийг бэхжүүлэх;**
- **Банк бус санхүүгийн байгууллагууд болон хөрөнгийн биржийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгэм болон засаглалын шаардлагуудыг нэвтрүүлэх, шаардлагатай бодлого, журам зааврыг боловсруулах,**
- **Санхүүгийн салбарын үйл ажиллагаанд уур амьсгалтай холбоотой эрсдэлийг хэмжих, үнэлэх, холбогдох хэрэгсэл, бодлогын зөвлөмжийг боловсруулах.**

Төсөл нь 2020 оноос 2023 оны хооронд ирэх 3 жилийн хугацаанд хэрэгжинэ.

- Монгол банк
- Санхүүгийн зохицуулах хороо
- Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо (ТоС Холбоо)
- Монголын Банкны Холбоо
- ББСБ-уудын Холбоо
- Арилжааны банкууд
- ББСБ-ууд
- Олон улсын байгууллагууд

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ НЬ ШУУД БИЕТ БОЛОН ШИЛЖИЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛҮҮДИЙГ БИЙ БОЛГОЖ БАЙНА

ШУУД БИЕТ БАЙДЛААР УЧИРАХ ЭРСДЭЛ

Уур амьсгал болон цаг агаарын өөрчлөлттэй холбоотой бий болох байгалийн гамшигт үзэгдлүүдээс үүсэх эрсдэл, хохирол

Жишээ:

- Ган зуд, үер ус, салхи шуурганы аюул нь бизнесийн үйл ажиллагаа, өмч хөрөнгөд хохирол учруулах


ШИЛЖИЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ УЧИРАХ ЭРСДЭЛ

Уур амьсгалийн өөрчлөлтөөс шалтгаалан өөрчлөгдөж буй зах зээлийн чиг хандлага, дүрэм журам, шаардлагуудад дасан зохицох, үйл ажиллагаагаа өөрчлөхтэй холбоотой бий болох эрсдэлийг хэлнэ.

Жишээ:


- Хэрэглэгчид байгаль орчинд илүү ээлтэй бүтээгдэхүүн худалан авах сонирхолтой болох
- Зохицуулагч байгууллагууд байгаль орчинд ээлтэй байдлаар үйл ажиллагаа явуулах, хөрөнгө оруулалт хийхийг шаардах

ЭДИЙН ЗАСАГ БОЛОН САНХҮҮГИЙН САЛБАРТ УУР АМЬСГАЛЫН ЭРСДЭЛИЙН ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨ





ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГУУД СТРЕС ТЕСТ ХИЙХ, ЗОХИЦУУЛАХ, ХЯНАН ШАЛГАХ БОДЛОГОДОО ХОЛБОГДОХ ӨӨРЧЛӨЛТҮҮДИЙГ ХИЙЖ БАЙНА

Panel A. Physical risk: forward-looking physical risk score of euro area firms



Source: ECB calculations based on the Four Twenty Seven dataset. Each dot corresponds to a firm in the sample. Gaps in the mapping are due to (a) economic activities being concentrated in specific industrial areas in some countries, and (b) Four Twenty Seven data not being available for latitudes above 60 degrees for flood risk. Other hazards include water stress, heat stress and hurricanes and typhoons. For simplicity only euro area firms are displayed in the chart, although data are available for a much broader sample.



САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУД УУР АМЬСГАЛЫН ЭРСДЭЛИЙГ ӨӨРСДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУСГАН, ХОЛБОГДОХ ӨӨРЧЛӨЛТҮҮДИЙГ ХИЙЖ БАЙНА

Эрсдэлийн удирдлага

Уур амьсгалын эрсдэлийг эрсдэлийн удирдлагын тогтолцоондоо тусган холбогдох хэрэгсэл, эрсдэлийн үнэлгээний аргачлалыг боловсруулах ажил хийгдэж байна.

Засаглал болон стратеги

Зарим санхүүгийн байгууллагууд өөрийн стратеги, бодлогодоо уур амьсгалын хүчин зүйлийг тусгаж, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын мэдлэг, мэдээллийг сайжруулах чиглэлээр ажиллаж байна.

Тайлагнал

Уур амьсгалтай холбоотой эрсдэлийн удирдлага, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар ил тод тайлагнах.



Бүтээгдэхүүн хөгжүүлэлт

Шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, үүнд ногоон/тогтвортой байдлын бонд, ногоон дэд бүтцийн хөрөнгө оруулалт, ногоон орон сууцны зээл, г.м

УУР АМЬСГАЛЫН ЭРСДЭЛИЙН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨГ ТООЦООЛОХ, ТААМАГЛАХ АРГАЧЛАЛ - СТРЕСС ТЕСТ



- Эрсдэлийн сценарийг биет эсвэл шилжилтийн эрсдэлтэй холбоотой тодорхойлох, мөн бүс нутаг болон тухайн улсын нөхцөл байдалтай холбоотой тодорхойлох




ДЭЛХИЙН БАНКНЫ БҮЛГИЙН ЗҮГЭЭС УЛС ОРНУУДАД ДАРААХ БАЙДЛААР ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭН АЖИЛЛАЖ БАЙНА

Морокко улс

Morocco – WB is supporting Bank-Al Maghrib with a climate risk assessment and the integration of climate risks into the regulatory and supervisory framework of banks


- 
-  1. Assessing climate-related risks in the financial system: Identifying and stress testing physical and transition risks
 -  2. Supervisory guidance and integration of climate risk in monitoring practices: Sector guidelines for scenario building, risk management, and reporting
 -  3. Training and awareness program: Providing support to build supervisory capacity, incl. development of training materials for supervisors and the sector
 -  4. Developing a taxonomy of green economic activities – Create a taxonomy for green or sustainable economic activities to categorize, label and monitor green investments.

Коломб улс




НОГООН БОНДЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

Top 2020 countries: Amount issued (2020 vs. Cumulative)



Q3 Use of Proceeds 2018-2020



Гол тоо мэдээлэл

- Зах зээлд гаргасан нийт ногоон бондын хэмжээ 1 триллион ам.доллар (90 тэрбум ОУ байгууллага)
- Тогтвортой байдлыг дэмжих зориулалттай бонд – 316 тэрбум ам.доллар
- 2020 онд 290 тэрбум ам.долларын ногоон бонд гаргасан.
- АНУ (71 гаргалт), Герман (48), Швед (40), Япон (30) зэрэг 39 гаруй улс орнуудаас ногоон бонд гаргаж байна.

НОГООН БОНД ГЭЖ ЮУ ВЭ?

Ногоон бондоор татсан хөрөнгийг зарцуулахад ОУСК нь уур амьсгалтай холбоотой үйл ажиллагааны өөрийн тодорхойлолт, тоон үзүүлэлтийг ашигладаг



Шаардлага хангасан төслүүдийн урьдчилсан хяналтыг гуравдагч талын хөндлөнгийн хяналтын үйл ажиллагаагаар дамжуулан хийдэг

Үйл ажиллагааны дараах тайлан нь хөрөнгө зарцуулалт болон санхүүжигдсэн төслийн үр нөлөөг шалгана. Бонд гаргагч нь санхүүжигдсэн төслүүдийн үр дүнгийн тайланг жил бүр гаргаж өгөх ёстой

НОГООН БОНДЫН ЗАРЧМУУД – ИЛ ТОД ТОГТОЛЦОО

Дөрвөн гол бүрэлдэхүүн хэсгүүд

[HTTPS://WWW.ICMAGROUP.ORG/GREEN-SOCIAL-AND-SUSTAINABILITY-BONDS/GREEN-BOND-PRINCIPLES-GBP/](https://www.icmagroup.org/green-social-and-sustainability-bonds/green-bond-principles-gbp/)

Татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах

- Татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах ногоон төслийн шаардлага хангасан ангиллуудыг (жишээлбэл, ОУСК-ийн уур амьсгалтай холбоотой үйл ажиллагааны өөрийн тодорхойлолт, тоон үзүүлэлт) тодорхойлж ногоон бондын холбогдох баримт бичгийн Хөрөнгө ашиглалт хэсэгт энэ талаар тайлагнах
- Бонд гаргагч нарын зүгээс хөрөнгө ашиглалтын талаарх сүүлийн үеийн мэдээллийг хөрөнгө бүрэн зарцуулагдаж дуусах хүртэл жил бүр шинэчилж хадгалах, энэ мэдээллийг ямар нэг асуудал гарсан үед ашиглах

Төслийн үнэлгээ, сонголт хийх үйл ажиллагаа

- Ногоон бонд гаргагч нь хөрөнгө оруулагчдад дараах зүйлүүдийн талаар тодорхой мэдэгдэж байх ёстой. Үүнд:
 - Байгаль орчны тогтвортой байдлын зорилтууд
 - Тухайн төсөл нь Ногоон төслийн ангилал дах шалгууруудыг хэрхэн хангаж буйг тогтоох үйл ажиллагаа
 - Тухайн төсөлтэй холбоотой болзошгүй байгаль орчин, нийгмийн эрсдлийг тодорхойлох, удирдахад хамаарах шалгуур, үйл ажиллагаа, эсвэл санхүүжүүлэхийг хориглосон төслүүд зэрэг мэдээллүүдийг агуулсан холбогдох шалгуурууд

Татан төвлөрүүлсэн хөрөнгийг удирдах

- Ногоон бондын татан төвлөрүүлсэн цэвэр хөрөнгө буюу энэхүү цэвэр хөрөнгөтэй тэнцэх хэмжээний дүнг дэд данс, дэд багцад шилжүүлэх эсвэл эсхүл бонд гаргагчийн зүгээс хянах боломжтой байдлаар зарцуулах, мөн бонд гаргагчийн Ногоон төслүүдэд хөрөнгө оруулах үйл ажиллагааны дотоод журмын дагуу бүртгэгдэж баталгаажсан байх шаардлагатай

Тайлагнал

- Бонд гаргагч нарын зүгээс хөрөнгө ашиглалтын талаарх сүүлийн үеийн мэдээллийг хөрөнгө бүрэн зарцуулагдаж дуусах хүртэл жил бүр шинэчилж хадгалах, энэ мэдээллийг ямар нэг асуудал гарсан үед ашиглах
- Жилийн тайланд татан төвлөрүүлсэн хөрөнгө хуваарилагдсан төслүүдийн жагсаалт, мөн төслийн товч танилцуулга, хуваарилагдсан дүн, болон хүлээгдэж буй үр дүг, нөлөөний талаар тусгасан байх ёстой.

ОУСК-ийн зүгээс бонд гаргагчдад дээрх заавар, зөвлөмжийг ойлгох, ашиглахад туслалцаа үзүүлэх боломжтой

НОГООН БОНДЫН ЗАРЧМУУДАЙ НИЙЦҮҮЛЭХ – ХӨНДЛӨНГИЙН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮНЭЛГЭЭ

Бонд гаргагчийн зүгээс олон төрлийн, олон түвшний хяналт, үнэлгээг хийлгэх боломжтой байдаг



Хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын санал, дүгнэлт

Байгаль орчны чиглэлээр мэргэшсэн, бонд гаргагч байгууллагаас хараат бус байгууллага нь Хоёрдагч талын санал, дүгнэлт гаргаж болно. Энэхүү байгууллага нь хоёрдогч талын санал, дүгнэлтийн хараат бус байдлыг хангах үүднээс ногоон бондын тогтолцоотой холбоотой бонд гаргагчид зөвлөгөө өгч буй зөвлөхөөс хараат бус байх ёстой. Ийм төрлийн байгууллага нь Ногоон бондын зарчимтай хэрхэн уялдаж байгааг үнэлэх үнэлгээг ихэвчлэн хийдэг. Тухайлбал, үүнд хүрээлэн буй орчны тогтвортой байдалтай холбогдуулан бонд гаргагчийн хэтийн зорилго, стратеги, бодлого, / эсвэл үйл явцыг үнэлэх, бондын хөрөнгийг ашиглахад зориулагдсан төслүүдийн байгаль орчны шинж чанарын үнэлгээ зэрэг орно.



Баталгаажуулалт

Бонд гаргагч нь өөрийн бизнесийн үйл явц эсвэл байгаль орчны шалгуур үзүүлэлтэд хамаарах шалгууруудад бие даасан баталгаажуулалт хийлгэх боломжтой. Баталгаажуулалтыг дотоод болон гадаадын холбогдох стандартад нийцсэн байдал эсвэл бонд гаргагчийн тодорхойлсон үзүүлэлтүүд дээр төвлөрөн хийж болно. Мөн санхүүжилт хийгдсэн төслүүдийн байгаль орчинд ээлтэй шинж чанарыг үнэлэх үйл ажиллагааг мөн баталгаажуулалт гэж нэрлэнэ. Татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах, хуваарилах, байгаль орчинд нөлөөлөх байдлын дүгнэлт эсвэл Ногоон бондын зарчимуудтай уялдсан байдал зэргийг хянан шалгах нь мөн баталгаажуулалт юм.



Гэрчилгээжүүлэлт

Бонд гаргагч нь өөрийн гаргасан ногоон бонд эсвэл холбогдох ногоон бонд гаргах үйл ажиллагааны тогтолцоо эсвэл татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах шалгуур зэрэг зүйлүүд дээрээ олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ногоон стандарт, шошгоны гэрчилгээ авч болдог. Ийм төрлийн стандарт эсвэл шошго нь тодорхой шалгуурыг хангасан байхыг шаардах бөгөөд ийм шалгууртай нийцүүлэх ажлыг мэргэшсэн, магадлан итгэмжлэгдсэн гуравдагч этгээд шалгаж гүйцэтгэдэг.



Ногоон бондын зэрэглэл тогтоох

Бонд гаргагч нь өөрийн гаргасан ногоон бонд, холбогдох ногоон бонд гаргах үйл ажиллагааны тогтолцоо эсвэл татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах шалгуур зэрэг зүйлүүд дээрээ олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөндлөнгийн судалгааны байгууллага эсвэл зэрэглэл тогтоох байгууллагаар тодорхой шалгуур, аргачлалын дагуу үнэлгээ хийлгэж болдог. Үнэлгээнээс гарах үр дүнд тухайн бонд гаргагчийн байгаль орчны гүйцэтгэлийн мэдээлэл, Ногоон бондын зарчимтай холбоотой үйл явц эсвэл уур амьсгалын 2 градусын өөрчлөлтийн хувилбар гэх мэт жишиг үзүүлэлтүүд орж болно. Ийм оноо / үнэлгээ нь зээлийн үнэлгээнээс ялгаатай бөгөөд байгаль орчинтой холбоотой болзошгүй эрсдлийг илэрхийлж болно.

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

bbatbold@ifc.org